

ДОРНОД АЙМАГ ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН 2023-2024 ОНЫ
ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 7 ДУГААР АНГИЙН МХБУЗ-ЫН ХИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

А ХУВИЛБАР

.....анги.....

ХУГАЦАА: 60 МИН

НИЙТ: 20 ОНОО

Эхийг уншаад утгыг ойлгож, даалгавраа гүйцэтгээрэй.

ХҮН БАЙХЫГ ЭРХЭМЛЭГЧ

Хандаа багш минь эрдэм боловсрол, элбэрэл хайр, авьяас билиг хосолсон ёстой л арван хуруу тэгш. Боловсролын салбарт гуч гаруй жил ажиллахдаа олон ч мундаг шавь төрүүлсэн.

Багш минь том алаг нүдтэй, хайр гэрэлтсэн зөөлөн харцтай, намбалаг, эрч хүчтэй, өөдрөг сэтгэлтэй, уужим бодолтой, шударга шулуун зантай, сайхан сэтгэлтэй. Багш гэхээрээ загнаж зандарч ойлгуулдаг биш, сурагчидтайгаа ойр дотно, найз шиг нь байж сурган хүмүүжүүлж болдгийг яруу тод харуулсан даа. Хичээлээ таслаад бөмбөг хөөчихдөг, гэрийн даалгавраа хийдэггүй шавь нараасаа болоод зэмлүүлж, багш нарын хурлаар “цоллуулж”, нүүрээ хийх газаргүй болтлоо ичиж, гомдож байсан үе танд зөндөө. Таныхаа хайраар бид эвсэг, хамтач сайхан хамт олон болж чадсан билээ. Багш маань бидэнд “Та нар математикч болохгүй, харин бүгдээрээ хүн болно. Хүн хүн шиг болохын тулд хүний мөстэй байх ёстой.” хэмээн сургадаг байв.

Та минь амьдралын ухаан, хүн байхын учрыг мэдрүүлсэн, буй биеэрээ хүн байхыг эрхэмлэгч.

Гүйцэтгэх даалгавар

1. Дараах үгсийг хам орчны утгаас нь эргэцүүлэн тайлбарлаарай. (2 оноо)

А. Арван хуруу тэгш.....
.....

Б. “Хөөчихдөг”.....
.....

2. Эхээс зэрэгцсэн нийлмэл үг бүхий 1 өгүүлбэрийг олж бичээд зэрэгцээ үгийг ялгаарай.(2 оноо)

Өгүүлбэр нь.....

Зэрэгцээ үг нь.....

3. Цэгийн оронд нэр ба үйлийн нөхцөлүүдийг залган өгүүлбэр бүтээгээрэй. (2 оноо)

Гэрийн даалгавар..... хийдэггүй шавь нар.....аа болж зэмлүүл....., багш нарын хурлаар “цоллуулж”, нүүрээ хийх газаргүй болтлоо ичин, гомд..... байсан үе түүнд бий.

4. Дээрх эхийг тоочимж хэв маяг болохыг жишээгээр батлан бичээрэй. (2 оноо)

ДОРНОД АЙМАГ ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН 2023-2024 ОНЫ
ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 7 ДУГААР АНГИЙН МХБУЗ-ЫН ХИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР
Б ХУВИЛБАР

.....анги..... ХУГАЦАА: 60 МИН НИЙТ: 20 ОНОО

Эхийг уншаад утгыг ойлгож, даалгавраа гүйцэтгээрэй.

ХҮН БАЙХЫГ ЭРХЭМЛЭГЧ

Хандаа багш минь эрдэм боловсрол, элбэрэл хайр, авьяас билиг хосолсон ёстой л арван хуруу тэгш. Боловсролын салбарт гуч гаруй жил ажиллахдаа олон ч мундаг шавь төрүүлсэн.

Багш минь том алаг нүдтэй, хайр гэрэлтсэн зөөлөн харцтай, намбалаг, эрч хүчтэй, өөдрөг сэтгэлтэй, уужим бодолтой, шударга шулуун зантай, сайхан сэтгэлтэй. Багш гэхээрээ загнаж зандарч ойлгуулдаг биш, сурагчидтайгаа ойр дотно, найз шиг нь байж сурган хүмүүжүүлж болдгийг яруу тод харуулсан даа. Хичээлээ таслаад бөмбөг хөөчихдөг, гэрийн даалгавраа хийдэггүй шавь нараасаа болоод зэмлүүлж, багш нарын хурлаар “цоллуулж”, нүүрээ хийх газаргүй болтлоо ичиж, гомдож байсан үе танд зөндөө. Таныхаа хайраар бид эвсэг, хамтач сайхан хамт олон болж чадсан билээ. Багш маань бидэнд “Та нар математикч болохгүй, харин бүгдээрээ хүн болно. Хүн хүн шиг болохын тулд хүний мөстэй байх ёстой.” хэмээн сургадаг байв.

Та минь амьдралын ухаан, хүн байхын учрыг мэдрүүлсэн, буй биеэрээ хүн байхыг эрхэмлэгч.

Гүйцэтгэх даалгавар

1. Дараах үгсийг хам орчны утгаас нь эргэцүүлэн тайлбарлаарай. (2 оноо)

А. “цоллуулж”.....

.....

Б. “Хүний мөс”.....

.....

2. Эхээс зэрэгцсэн нийлмэл үг бүхий 1 өгүүлбэрийг олж бичээд зэрэгцээ үгийг ялгаарай.(2 оноо)

Өгүүлбэр нь.....

Зэрэгцээ үг нь.....

3. Цэгийн оронд нэр ба үйлийн нөхцөлүүдийг залган утга төгс өгүүлбэр бүтээгээрэй. (2 оноо)

Багш гэх.....ээ загна..... зандарч ойлгуулдаг биш, сурагчид.....аа ойр дотно, найз шиг нь байж сурган хүмүүжүүл..... болдгийг яруу тод харуулсан даа.

4. Дээрх эхийг тоочимж хэв маяг болохыг жишээгээр батлан бичээрэй. (2 оноо)

.....
.....
.....

5. “амьдралын” хэмээх үгэнд ХТЯ-ын “ын,ийн⁴ нөхцөл залгах зөв бичих дүрмийг тайлбарлан бичнэ үү? (2 оноо)

.....
.....

6. Сургаал шүлгийг зөв тохируулан харгалзуулж (2) шүлгийн утга санааг 20-25 үгэнд багтаан дүгнэн бичээрэй (3). Нийт 5 оноо

- | | |
|---|------------------------------------|
| I. Алтын арчваас улам өнгө гарах. | а. Оорцог хүний идэш болох |
| II.Мэргэдийг хорсговол улам эрдэм гарах | б. Нүүрсийг угаавал улам харлах |
| III.Олон хүн эвгүй бол | в. Эвдэрхий хүрээ мэт хэврэг |
| IV. Хорин хүн эвгүй болбоос | г. Мунхгуудыг хорсговол баас гарах |

Дүгнэлт.....
.....
.....

7. Үндэсний бичгээс кирилл бичигт хөрвүүлээрэй. (5оноо)

سَمِيرٌ كَلِمٌ عَيْشِمِرٌ سَوَيْبٌ وَحَلِيفٌ هُوَ
وَخَلِيفٌ كَلِمٌ هُوَ عَيْشِمِرٌ كَلِمٌ هُوَ
عَيْشِمِرٌ كَلِمٌ هُوَ سَمِيرٌ كَلِمٌ هُوَ
عَيْشِمِرٌ كَلِمٌ هُوَ سَمِيرٌ كَلِمٌ هُوَ
عَيْشِمِرٌ كَلِمٌ هُوَ سَمِيرٌ كَلِمٌ هُوَ

.....
.....
.....
.....
.....
.....

Асуулт	1	2	3	4	5	6	7	нийт	хувь	Түвшин
оноо	4	4	4	2	2	5	2	20		
Авсан оноо										

Шалгасан багшийн нэр, гарын үсэг.....

